

**Х.МИЖИДДОРЖ**  
**«СИТИ» Их сургуулийн Сургалтын төвийн захирал.**  
**Магистр**

## **ДУНДАД ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛ ЯЗГУУРТНЫ ДЭЭЛНИЙ ХЭЭ ЧИМЭГЛЭЛИЙН ДҮРСЛЭЛИЙН ОНЦЛОГТ ХИЙСЭН СУДАЛГАА**

### **Товч хураангуй**

Монголчууд дээл хувцас, хэрэглэл, түүний чимэглэлийн олон зуун жилийн уламжлалтай. Тэдгээрийн бэлгэдэл, утга агуулгыг үеийн үед ямагт хадгалан өнөө үед уламжлуулан үлдээжээ. Монголын ихэс дээдэс хувцасны өөрийн гэсэн төрөл, хэлбэртэй байсан бөгөөд хуулиар тогтоогдсон хувцас хунар хэв загвар нь төр ёсны зориулалттай байжээ.

Дундад зууны үеийн Монголын язгууртнуудын төрт ёсны бэлгэдэл, дээлний загвар, хээ чимэглэл нь дахин давтагдашгүй үндэстний уламжлалыг хадгалсан байдаг бөгөөд азийн бусад улс орнуудын үндэсний хувцасны загвар, материал, хээ чимэглэлээс эрс ялгаатай байжээ. Торго гэхээр хятад, хээ угалз гэхээр мөн л тэдгээр торго үйлдвэрлэгчдээс уламжилсан гэдэг буруу ташаа ойлголт байдаг. Энэхүү ташаа ойлголтыг бодит баримт судалгаанд тулгуурлан задруулах оролдлогыг хийх нь бидний зорилго юм.

### **Түлхүүр үг**

Монгол дээл, загвар урлал, хээ угалз, зохиомж дүрслэл, төрт ёсны билэгдэл, язгууртан, чимэглэл

## Оршил

Даяарчлагдаж буй мэдээлэл технологийн эрин үед улс үндэстнүүдийн тулгамдсан асуудал нь үндэсний бахархал болсон өв уламжлал, язгуур соёлоо хадгалж үлдэх асуудал болоод байна. Үүний нэг тод жишээ бол монголчуудын хувцасны соёл, түүний талаарх мэдлэг, генетик нөөцийн тухай асуудал юм.

Монголчуудын түүхэн хөгжлийн явцад язгууртнуудын дээл хувцас нь ёс заншил, бэлгэдэл, нийгмийн хөгжлийн өөрчлөлт зэргийг тусган уламжлагдан шинэчлэгдэж ирсэн оюуны болон эдийн үнэт зүйл бөгөөд цэцэн ухаант өвөг дээдэс, эрдэмтэн мэргэдийн хуримтлуулан баяжуулж ирсэн соёлын сан хөмрөгөөс хойч үе суралцан сэтгэл оюунаа сэлбэн, хөгжүүлэн шинэчлэх учиртай билээ.

Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “торго” гэдэг үгийг “Үгийн уг үндэс тор нь сийрэг саргар нэхээстэй юм ба торгыг ёнхор мяндсаар нягт нэхсэн хээнцэр эд” хэмээн тайлбарласан байдаг. Дундад зууны үеийн Монголын язгууртнууд дээл хувцсандаа торгыг ихээр хэрэглэдэг байжээ. Монголчууд өнөөг хүртэл Хятад, Энэтхэг гэх мэт гаднын улсын торгыг өөрсдийнх нь хээ бэлгэдэлтэйгээр хэрэглэсээр ирсэн боловч торгоны хээ загварын

хувьд өөрийн орны түүх, соёл уламжлал, бэлгэдэл өөр байснаас болж торгоны хээ дүрслэлийг өөрсдөө урлаж байсан баримтыг Дундад зууны үеийн хувцас, урлагийн бүтээл болон эд хэрэглэгдэхүүний соёлоос харж болно.

Азийн урлаг судлалын тэргүүн, эрдэмтэн James C.Y.Watt “Төв Азиас олдсон Хятадад хадгалагдаж байгаа Монголын эзэнт гүрний үед арьсан дээр урласан бүтээл нь ертөнцийг тэр чигт нь харуулсан зохиомжтой, бэлгэдлийн хувьд өргөн агууламжтай бөгөөд цэнхэр өнгө нь далай тэнгис, ногоон өнгө нь газар дэлхий, цагаан өнгө нь идээ цагаа, цагаан цайлган сэтгэл, улаан нь гал, шар өнгө нь энх тайвныг, тойрсон зүйлс нь уул, усыг харуулсан” байна хэмээн тэмдэглэсэн байна. Монголчуудын хээ хуарын бүтээл нь ертөнц дэлхийн шүтэлцээ холбоо, энх тайван, байгаль дэлхийг харуулсан байдаг гэдгийг судлаач энд онцолсон байна. Монголчуудын дээл хувцсандаа чимэглэж байсан хээ хуар нь Төв Азийн бусад орны ард түмний эдлэл хэрэглэлийн хээнээс огт өөр шинэлэг байсан бөгөөд монголчуудын сэтгэлгээний онцлогийг ямар нэг байдлаар батлан харуулж байна.

XIII-XIV зуунд Хубилай хааны үеийн Бээжин хотод хадгалагдан үлдсэн бүтээл болох

Юан улсын Монгол хаад, хатдын хөрөг зураг байдаг. Уг хөрөг зураг дээр дүрслэгдсэн ноёд, хатдын дээл хувцас нь хүннүгийн үеэс уламжилсан монгол хувцас, дээлийн загварыг тод илтгэж байдаг. “Хубилай хааны үед монголчуудад түгээмэл дэлгэрсэн хувцасны загвар, материал нь Хятадын үндсэн загвар байсан” ба “XIII зууны үед Монгол гүрний их хаан ... тайлга ёслолын хувцасны дүрэм хуулийг удаа дараа гарган тогтоосон бөгөөд ингэхдээ хуучин хэлбэр /уугуул монгол янз/-ийг хэвээр авч чимгийг маш их болгосон” хэмээснийг үзвэл тухайн үед гадны торго дурданг хэрэглэж байсан боловч монгол үндэстнийхээ соёл, уламжлал, билэгдлийг дээл хувцсандаа тусган урласаар ирсэн байна.



Зураг 1. Монголын эзэнт гүрний үед арьсан дээр урласан бүтээл



Зураг 2. Энэтхэгээс гаралтай буддизмын урлаг. Юан улсын Монгол хаад, хатдын хөрөг зураг

Түүхийн сурвалж мэдээнээс үзэхэд монголчууд эртнээс нааш хувцас хэрэглэлдээ ихэд анхаарч, тэр ч битгий хэл тусгайлан хууль гаргаж, харьяат улсын дотор журамлан мэдүүлсээр иржээ. Монгол газар анхны төр улс байгуулсан Хүннү нар өөрийн хувцасны хуультай байсны дээр киданчууд 928 онд Дай Ляо улсыг байгуулаад мөн хувцасны дүрэм зохион хэрэгжүүлжээ. Монголын их эзэнт гүрний үед их хаан Мөнх 1252 онд, Хубилай 1275 онд тус тус хувцасны хууль гарган хувцасны хэв маягийг тогтоосон тухай угсаатны зүйч эрдэмтэн нар зохиол бүтээлдээ бичсэн байдаг. Эдгээр хуулиар тогтоогдсон хувцас хунар, түүний хэв загвар нь Монголын ихэс дээдсийн төр ёсны зориулалттай байжээ.

Угсаатны зүйч Г.Бадрах нангиад толь, сурвалж бичиг шүүрдэн XIII зууныг хүртэлх үеийн

монгол хувцасны тухай хэрэглэгдэхүүнүүдийг цуглуулж, ном, эх бичигт үндэслэн монголчуудын ихэс дээдсийн хувцасны төрөл, хэлбэрийг "Тайллын хувцас", "Төрийн хувцас", "Албаны хувцас", "Ерийн хувцас", "Авын хувцас", "Гашуудлын хувцас"3 гэж ангилсан нь монгол хувцас ёслол, төр ёсны хүндэтгэлийн илэрхийлэл болж байсныг харуулж байна.

Эрдэмтэн Х.Нямбуугийн тодруулснаар "Түшмэдийн зүсмийн хувцас, албаны хувцас, хааны ёслолын луут дээл зэрэг нь тогтоосон дэг журамтай байхын зэрэгцээ ... хааны луут дээлийг хар хурмаш сиймхийгээр давхар хийгээд дээлийн гадар өнгөт алтан хээтэй байх ба таван өнгийн дотор алт холилдуулж нар сар, одон гариг, мяндсан луу, давхар биет луу, гургуул, барс, бичигт хундага зэргийг хатгамлан оёдог" болохыг дурджээ. Тэрчлэн "...Их тайлгад



Зураг 3. Чингис хааныг 1206 онд Онон мөрний хөвөөнд Их хуралдайгаар их хаанд өргөмжилж буй нь



хаан нь алтан хээтэй алтан малгай, цагаан нягт хив дээл, улаан бүс, хирсний эвэр, хас зэргийг шигтгэсэн хутга хуурай зүүх бөгөөд туурын оёдолт хар гутал өмсөнө. ...Бага тайлгадаа хаан нь хатуу малгай, улаан утсаар оёсон яст мэлхий хээтэй дээл өмсөх ба хатан улаан хив алчуур нөмөрч, хас чимэг зүүн, хар гутал өмсөнө.

...Хааны ерийн

өмсөх хувцас нь ногоон хээтэй чухал дээл бөгөөд улаавтар ногооныг үлэмж хэрэглэнэ” гэж тэмдэглэсэн байна. Эдгээр баримтад дээлийн талаар “тогтмол хээтэй, өнгөт алтан утсаар хээлэн хатгамлан оёсон” гэж тодотгон өгсөн байна. Үүнээс үзэхэд тухайн үед монголчууд дээл хувцсандаа хээ чимэглэлийг өргөн хэрэглэдэг байсан гэдэг нь нотлогдож байна.

“Монгол үндэстний хээ угалз нь ард түмний байгаль орчинтой харьцах харилцаа, түүнийг өдөр тутмын ахуй байдалдаа тусгах, гоо сайхны сэтгэлгээний үр дүнд үүссэн яруу хэллэгтэй, өлзий буян, өнгө ба бэлгэдэл зөн билгийн санаа агуулсан ардын өвөрмөц урлаг. Хээ угалз нь эдийг буюу эзнээ чимэх, сайхан болгохоос гадна эдлэх эзэндээ ерөөл болгож ашдын бэлгэ, энх жаргал, өлзий баяр, заяа буян бодсон маш эртний уламжлалт зан үйлийн шинжийг өөртөө хадгалж иржээ” гэж эрдэмтэн Ц.Ядамжав судалгааны бүтээлдээ дурдсан байдаг.

XIV зууны үед бүтээгдсэн Монголын Их хаадын үеийн номын чимэглэл зургийн хамгийн алдартай дурсгал болох Перс түүхч Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-ы чимэг зургууд нь хүмүүн төрөлхтний оюун санааны ховор чухал дурсгал болон мөнхөрсөн билээ. Энэ түүхэн бүтээлд дүрслэн үзүүлсэн монголчуудын дүр төрх, хувцас сэлт нь Монголын их хаадад бараалхахаар айлчлан ирсэн тэр үеийн хүмүүсийн ахуй байдлын талаар тэмдэглэн бичсэн харь орны элч төлөөлөгчдийн өгүүлсэнтэй бүрэн дүйх ажээ.

Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-ы

тайлбар зурагт “... дээлийн энгэр, дал мөр, хормой дээр дүрсэлсэн хээ угалз гоёл чимгийг нэгд нэгэнгүй тусгажээ” . Судрын чимэг зургаас үзэхэд Чингис хааны дээлийн энгэрийн хээг торгон дээр алтан утсаар оёсон байх бөгөөд хааны төрөл төрөгсөд болон түшмэд ноёдын хувцсан дээр хээ угалзыг шаглан урладаг байсан нь тодорхой харагдаж байна.

XIII-XIV зууны үеийн Монголын язгууртнууд угалз хээг дээл хувцсандаа өргөн хэрэглэдэг байсан тухай сурвалж бичгүүдэд тэмдэглэн үлдээжээ. Марко Пологийн 1293 онд бичсэн “Орчлонгийн элдэв сонин” хэмээх номд энэ талаар тодорхой өгүүлсэн байдаг. “Тэдний хувцас гэвэл баячууд нь алтан саатай магнаг торгоор хийж, ... Их хаан төрсөн өдрөө алтан утсаар хээлэн оёсон үзэсгэлэнт сайхан цэмбэн дээл өмсөх ба нэгэн түм хоёр мянган ноёд (жанжин) баатар эрс мөн их хааны нэгэн адил хувцас өмсөх аж. Тэдний дээлийн цэмбэ төдий л үнэтэй бус болой. Энэ хувцсыг тэдэнд их хаан бэлэг болгон барьжээ. Харин эрдэнийн чулуу, сувд, тана шигтгэн хээлж оёсон зарим дээл түм гаруй бизантын үнэтэй. Тийм дээл олон буй. Их хаан нэгэн түм хоёр мянган ноёд, баатар эрсдээ жилд арван гурван удаа өөрийн хэрэглэдэг шиг их үнэтэй сайхан хувцас бэлэглэдэг” гэж онцлон тэмдэглэсэн байна. Монголчуудын дээл хувцас нь алтан утсаар болон эрдэнээр шигтгэн хээлэн оёсон үзэсгэлэнтэй сайхан, ихэс дээдэс үнэтэй дээл хувцсаар гоёдог тухай энд тодорхой хэлжээ. Тэрчлэн монголчууд торгыг байгаа чигээр нь хэрэглэдэггүй, хээ угалзаар зээглэн чимэглэдэг байсан тухай энд онцолсон байна.



Зураг 4. Монголын их эзэнт гүрний үеийн язгууртны дээл



Мөн Жиованни дель Пано Карпинигийн зохиолд “Тэд дээлээ Бухарын ноосон даавуу, ал улаан бөс буюу Багдад торго хоргойгоор дараах маягаар хийнэ. ... Эхний өдөр цөм цагаан магнаг торго, дараагийн өдөр нь улаан магнаг торгон хувцас өмссөн бөгөөд гурав дахь өдөр нь бүгд номин хөх магнаг торгон хувцас, дөрөв дэх өдөр нь үлэмж тансаг хоргой хувцас өмссөн байж билээ” хэмээн дурджээ.

1237 онд Монголд ирсэн Сүн улсын элчин Пэн Да Я болон Сюй Тин нарын хамтран бичсэн “Хар Татаарын хэргийн тухай товч” зохиолд өгүүлснээр “... Тэдний хувцас хунар гэвэл энгэрээ зөв тийш дарж, зах нь дөрвөлжин хуучин эсгийгээр эсгэж, арьсан шижмээр оёдог, олсон шир утсаар үйлдэнэ. Өнгө нь улаан бор, элгэн ногоон бөгөөд нар, луу, гарьд тэргүүтний зурагтай. Үүнд эрхэм, доордын ялгаа гэж байхгүй. ...

Тэд сүүжнийхээ дээр тоолшгүй нарийн нугалаас гаргадаг, уужуу хувцсанд бол арван хоёр нугалбартай. Тэр үеийн Монголын нийт хүмүүсийн дээл нь ташуу мөөрөлжин, зөв энгэртэй байсан бөгөөд дээхэн үедээ бүдүүн цэмбэ, арьсан дээл өмсдөг байснаа хожим бөс, торгомсог, алт хатгамласан торгомсог дээл өмсдөг болжээ” гэж эрдэмтэн Х.Нямбуу судалгааныхаа бүтээлд өгүүлсэн байдаг.

Эдгээр ном зохиолд дурдсанаас үзэхэд Монголын язгууртнууд эртнээс дээл хувцандаа өөрсдийн уламжлал, зан үйлийн бэлгэдлийг тусгаж, түүнийгээ алтан утас болон үнэт эрдэнийн зүйлээр шигтгэн хээ угалз чимэглэн урлаж байжээ.

2003 онд МҮТМ-ын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Аюуш, Ж.Баярсайхан, Г.Рэгзэн, археологич Г.Мэнэс нар Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэн Баян Улааны “Бухын хошуу” хэмээх газар буй булшнаас ховор сонин олдвор, түүх археологийн чухал хэрэглэгдэхүүн болох гоёмсог хээ угалз эмжээр бүхий торгон дээл, өргөн эмжээртэй торгон дан дээл, өрөөсөн алтан ээмэг, сэлэм, дөрөө, хутганы эвлэж болохуйц хэсгүүд зэрэг олон зүйл олсон юм.

Судлаач Ж.Баярсайхан дээрх олдворыг малтан шинжилж байсан бусад булшны материалуудтай харьцуулан үзээд “Эдгээрийг XII-XIV зууны үед холбогдуулж болмоор байна. Энэ булшнаас гарсан сумч хутганы хугархай, дөрөөний хэсгүүд, дээл хувцасны энгэр болон бусад зүйлс нь Монголын эзэнт гүрний үед холбогдох бусад дурсгалуудтай ижилсэж байгаа нь тухайн олдворуудын үнэ цэнийг тодорхойлох чухал зүйл болж байна” гэж дүгнэсэн байна.

Доорх зураг дээрх дээлийг Монголын язгууртнууд өмсөж хэрэглэж байсан ба тухайн дээлтэй төстэй зургуудыг Дундад эртний

үеийн сурвалж, хөшөө чулуун дүрслэл, археологийн олдвор, эртний номын чимэг зургуудаас харж болно.

Монгол язгууртны эл дээлийг нарийн нэхээстэй торгоор хийж, мөр, энгэр, хормой, ташаа, ханцуйн үзүүр, бугалга зэргийг уламжлалт үргэлжилсэн эвэр угалзан хээ, энгэр захыг тойруулан үргэлжилсэн хамар угалз хээгээр чимэглэж, чимгийг эрчилсэн утсаар зээглэж оёсон байна. Тухайн үед Монголын язгууртан ноёд дээлийнхээ энгэр, дал мөрөнд хээ угалз гарган оёх ёс заншилтай байсан бөгөөд өнөөдөр өөрчлөгдөн хувьсаж, монголчуудын хэрэглэдэг додигны хэлбэр загвар болсныг урлагийн бүтээлүүдэд дүрсэлжээ. “Эвэр угалз бол Монголын амьтны дүрст хээ угалзны нэг том төрөл бөгөөд Алтай, түүний хавь нутагт орших туурайтан амьтны сүрлэг үзэсгэлэнтэй эврээс үүсэлтэй” юм. “Эвэр, ээмэг, ээтэн гэх мэт нь дугараг эргэсэн матийсан гэсэн утгатай эвэр гэсэн утгаараа бөх үлдэж, угалз нь ам өрх гэж айл гэрийг нэрлэдгийн адил юмны бүх хэсгээр бүхлийг нэрлэсэн” байна. “Мөн хуйларч эрчилсэн салхийг говийнхон “угалз” хэмээн нэрлэдэг бөгөөд хээ нь түүний язгуур үндэс болсон угалзаас улбаалан үүссэн тул Монгол хээ угалзыг “Угалзан урлаг” хэмээдэг”.

Энэ мэт ихэнх хээ нь монгол ардын аж байдлаас эхтэй, бодит үндэстэй монгол үгээр нэрлэгдсэн байна. “Амьтдын эврийг эртний зураачид ихэд анзаарч шохоорхсоныг бид бас нэн анхаарах нь зүй. Учир нь ерөөс хийсвэр сэтгэхүй элдэв сонин хачин дүрс тэмдэгт дулдуйдан бясалгах уугуул шинжтэйн сацуу эвэр дүрсээс хожмын элдэв тамга тэмдэг гарсны зэрэгцээ эвэр нь нарийн нийлмэл утгат томъёо тэмдэг хэлхэж бүтээх арал болсон” бөгөөд монголчууд олон мянган жилийн шууд уламжлалтай үндэсний ба язгуур үзэл суртлын сүлд тэмдэг бүхий ганц улс түмэн билээ.

Ийнхүү Дундад зууны үеийн Монгол язгууртны дээлийн хээ чимэглэлийн талаар дотоод, гадаадын судлаачдын бүтээл багагүй байгаагийн дээр соёлын талаар холбогдох ард түмний судалгааны хэрэглэгдэхүүн нь Монгол үндэстний хувцас болон түүний хээ чимэглэлийн түүхийг боловсруулахад ихээхэн дэм үзүүлж байна.

## Дүгнэлт

Дээрх бүгдээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Монголын ихэс дээдэс үндэсний өвөрмөц онцлог бүхий дээл хувцасны төрөл, хэлбэртэй байсан бөгөөд хэв загвар, хээ чимэглэлийг хуулиар тогтоож, төрийн ёслол хүндэтгэлийн зориулалтыг зааж өгсөн нарийн дэг журамтай байжээ.
- Дундад зууны үеийн Монголын язгууртнууд төрт ёсны арга хэмжээнд дээл хувцсандаа билэгдлийн шинжтэй, үзэсгэлэнтэй, үнэтэй, давтагдашгүй утгыг агуулсан чимэглэл бүхий хувцас хэрэглэдэг байсан байна.
- Монголын ихэс язгууртнууд торгыг байгаа чигээр нь хэрэглэдэггүй байсан бөгөөд Бухарын ноосон даавуу, өнгө өнгийн магнаг торго, хоргойгоор үлэмж тансаг торгон хувцас хийж, түүн дээрээ дахин давтагдашгүй үндэстний уламжлалыг хадгалсан өөрсдийн бэлгэдэлтэй хээ хуараар чимэглэн урлаж өмсөн хэрэглэдэг уламжлалтай байжээ.
- Дундад зууны үеийн Монголын язгууртнууд төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд өмсөх дээл хувцсандаа үндэснийхээ бэлгэдэлтэй хээ хуарыг

алтан утас болон эрдэнийн зүйлээр чимэглэн зээгт наамлын аргаар давхар шаглан урлаж, ардын урлагийн баян тансаг өв санг бүтээж байсныг түүхийн эх сурвалж, номын чимэг зураг, эртний үеийн сурвалж бичиг, археологийн олдворуудаас харагдаж байна.

- Дундад зууны үеийн Монголын язгууртнуудын дээл хувцасны загвар, хээ чимэглэл нь үндэстний давтагдашгүй уламжлалыг хадгалсан бөгөөд дээл хувцасны загвар, эх материал болох торго түүний хээ чимэглэл нь Дундад Азийн улс орнуудын хувцасны загвар, материал, хээ чимэглэлээс өөр байсан бөгөөд өөрийн гэсэн үндэстний онцлог шинжийг өөртөө агуулсан байна.
- Монголчууд зөвхөн өөр хоорондоо төдийгүй Ойрх Дорнод, БНХАУ-д хүртэл өөрсдийн хувцасны соёлыг түгээн дэлгэрүүлж тэдний өв соёлд томоохон нөлөө үзүүлж байсан ард түмэн юм. Иймд уламжлалт өв соёлоо хадгалан, цаашид хөгжүүлэн дэвжүүлэх, үндэстний бахархал болсон хувцас загвар тэр дундаа язгууртнуудын дээл хувцсыг Монгол төрийн хэмжээнд судалж боловсруулах шаардлагатай байна.

### Ашигласан номын жагсаалт:

#### **Нэг. Монгол хэлээр хэвлэгдсэн бүтээлүүд**

1. Бадрах Г. Чингис хаанаас дээд үеийн өвөг дээдсийн Монгол хувцас. УБ., 2006.
2. Баяр Д. Перс номын чимэглэл зурагт хадгалагдан үлдсэн дундад зууны Монголын уран зургийн зарим мэдээ //Түүхийн судлал. №24.УБ.,1990.
3. Баярсайхан Ж. Судалгааны ажил.УБ., 2008.
4. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. УБ.,1985.
5. Нямбуу Х. Монгол хувцасны түүх. Түүхийн ухааны докторын зэрэг горилсон диссертац. УБ.,1993.
6. Нямбуу Х. Халхын зарим нутгийн хээ угалзны зүйлээс.УБ.,1968.
7. Төмөрхуяг Ж. Хээ угалз бүтээх аргууд. УБ.,2010.
8. Эрдэнэ Ч. Их гурвалжин. УБ., 2002.
9. Ядамжав Ц. Монгол ардын хээ угалзын эх дүрсүүд. УБ.,1985.
10. Ядамжав Ц. Хээ угалз. УБ.,1995.

#### **Хоёр. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээлүүд**

1. James C.Y.Watt Brooke russell astor chairman department of asian art.mma “The world of KUBILAI khan: Chinese art in the yuan dynasty-a retrospective” October 8. 2010.
2. Марко Поло. Кочевник Азии. М., 1976.



Erasmus  
Mundus

## ERASMUS MUNDUS

**М**анай хамт олноос гадаад харилцаандаа баримталж байгаа зарчим болон хэрэгжүүлж байгаа үндсэн бодлого бол дэлхийн нэр хүндтэй сургуулиудтай солилцооны хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх замаар багш, оюутан, ажилтнуудынхаа мэргэжлийн болон хувь хүний өсөлт, хөгжлийг дэмжиж, үндэсний дээд боловсрол төдийгүй улсын хөгжилд хувь нэмрээ оруулах өндөр мэдлэг, чадвар, хандлагатай мэргэжилтэн, багш, судлаачдыг бэлтгэх явдал юм.

Энэхүү бодлого, зарчмын хүрээнд бид 2014 оноос Европын Холбооны дээд боловсролын тэтгэлэгт солилцооны ERASMUS MUNDUS MOBILITY ASIA /EMMA/ хөтөлбөрийн Монгол Улс дахь түнш байгууллагаар сонгогдон ажиллаж, уг хөтөлбөрийн хүрээнд 30 гаруй багш, оюутнууд Франц, Итали, Польш Улсад амжилттай суралцуулаад байна.

Европын Холбооны “Erasmus Mundus Mobility with Asia” хөтөлбөрийн хүрээнд “СИТИ” Их сургууль дараах төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд:

2013 оноос Францын Ницца хотын Софиа Антиполис их сургуультай хамтран Дээд боловсролын тэтгэлэгт солилцооны Erasmus Mundus” хөтөлбөр;

2016 оноос “Их сургууль, бизнесийн байгууллагын түншлэлийг бэхжүүлэх Erasmus+” төсөл;

2017-2018 онд “Ажил эрхлэлт ба мэргэжлийн өсөлтийн талаар их сургуулиас үзүүлж буй үйлчилгээний менежмент” төсөл.

Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Та “СИТИ” Их сургуулийн Гадаад харилцааны албанаас аваарай.

**Танд амжилт хүсье. Баярлалаа.**

